



## ЭРХИЙН МЭДЭГДЭЛ

Цагдаад баривчлагдан хоригдсон хүнд олгох  
(16-18 өсвөр насны, хүрээгүй этгээд-эрүүгийн хэргийн хуулийн  
706-73 бүлгийн дагуу зөрчил гаргасан насанд хүрэгчтэй  
хамтарсан эсвэл хамсаатан болон гэмт хэрэг үйлдсэн )

**Дор өгөгдсөн мэдээллүүд таны ойлгох хэл дээр өгөгдсөн байх ёстой.**

**Та цагдаад баривчлагдан хоригдох хугацаанд уг баримтыг хадгалж болно**

Таныг насанд хүрэгчтэй хамтарсан эсвэл хамсаатан болон шоронд хоригдох ялаар шийтгэгдэх эрүүгийн гэмт хэрэг, зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдсэн, эсвэл үйлдэхийг завдсан хэмээн сэжиглэж буй нэг ба хэд хэдэн шалтгаан байгаа байгаа учраас та цагдаад баривчлагдан хоригдож байгааг танд мэдэгдэж байгаа болно.

Та таныг сэжиглэж буй, уг гэмт хэрэг зөрчил гарсан, огноо ба газрыг мөн түүний зүйлчлэл, цагдаа баривчлан хорих болсон шалтгааныг мэдэх эрхтэй.

Хорин дөрвөн цагаар үргэлжилж болох цагдаад хоригдох явцад та уг хэргийн талаар мэдүүлэг өгнө.

Уг хугацаа дууссаны дараа Улсын прокурор (эсвэл хяналтын прокурор) таны цагдаад хоригдох хугацааг нэмэлт хорин дөрвөн цагаар сунгаж болно. Тантай Прокурор биечлэн уулзах, боломжгүй бол видео хурал хийнэ

Онцгой тохиолдолд, хэрэв мөрдөн байцаалт буюу хэрэг бүрдүүлэлтийн хэрэгцээ шаардлагыг харгалзан, Цагдан хорих болон суллах асуудлыг шийдвэрлэх эрх бүхий шүүгч болон Улсын прокурорын хүсэлтээр цагдаад хоригдох хугацааг хоёр удаа хорин дөрвөн цагаар сунгаж болдог.

Уг цагдаад хорих хугацаа дууссаны дараа хяналтын прокурор буюу Улсын прокурорын шийдвэрээр энэ Прокурортой биечлэн уулзах юмуу нэг бол таныг суллана. Эхний тохиолдолд та өөрийн хорих хугацаа дууссан цагаас тоолон 20 цагийн дотор шүүх хуралд орно. Үүнд таны түр хоригдох хугацаа 72 цагаас илүү байсан тохиолдол орохгүй.

### **ТАНЫ БУСАД ЭРХИЙГ МЭДЭЭЛЖ БАЙНА :**

#### **Хэсэг хүмүүст хэлүүлж мэдэгдэх эрхтэй**

Цагдаагийн ажилтан буюу мөрдөн байцаагч таны эцэг эх эсвэл таны асран хамгаалагч, эсвэл таны хариуцагч байгууллагад цагдаа хоригж буй талаар хэл мэдүүлнэ.

Та өөрийн ажил олгогчид мэдэгдэж болно.

Хэрэв та гадаадын иргэн бол өөрийн улсын консулын газарт мэдэгдэх хүсэлт гаргаж болно.

Улсын прокурор (эсвэл хяналтын прокурор ) нь мөрдөн байцаалтын хэрэгцээ шаардлагаас хамааран эдгээр хүсэлтээс татгалзах эрхтэй. Онц хүнд байдалд ороогүй л бол, хүсэлттэй танилцаад, 3 цагийн дотор гурван цагийн дотор арга хэмжээ авагдана.

#### **Эмчээр үзлэг хийлгэх**

Та эмчийн үзлэг хийлгэх хүсэлт гаргаж болно. Таныг түр хорих хугацааг уртсгах

тохиолдолд та давтан эмчийн үзлэгт орохыг шаардаж болно. Хоёр хоног цагдаад хоригдсоны дараа хорих хугацааг дахин сунгахаар шийдсэн бол та хугацаа сунгах бүрд эмчийн үзлэгээр зайлшгүй орно. Уг хүсэлтүүдийг таны эцэг эх, таныг хариулагч эсвэл таныг даасан хүн гаргаж болно.

**Та дуугарахгүй чимээгүй байх эсвэл, эсвэл асуултууданд хариулан байцаалтаа өгч болно.**

Та өөрийн биеийн байцаалтаа хэлсний дараа байцаалт өгөхдөө доорхи эрхийг эдэлнэ:

- мэдүүлгээ өгөх,
- Танаас асуусан асуултууданд хариулах,
- үг дуугарахгүй байх

**Өмгөөлөгчийн туслалцаа авах**

**- Өмгөөлөгч сонгох**

Цагдаа хорих мөчөөс эхлэн мөн таны хориог сунгасан тохиолдолд сунгасан цагаас эхлэн та өөрийн сонгосон өмгөөлөгчийн тусламж авах эрхтэй. Та өөрөө өмгөөлөгчөө сонгох боломжгүй эсвэл таны өмгөөлөгчтэй холбогдох боломжгүй бол улсаас танд үнэгүй туслалцаа үзүүлэхээр томилсон өмгөөлөгчийг авах хүсэлт тавих эрхтэй.

Таны өмгөөлөгчийг таны эцэг эх эсвэл таны, асран хамгаалагч эсвэл таныг хариуцсан байгууллага сонгож болно.

**- Өмгөөлөгчийн туслалцаа ба оролцооны хугацаа**

Өмгөөлөгч нь:

- ярилцлагын нууц байдлыг чанд хадгалсан нөхцөлд таньтай 30 минут ярилцана,
- хэрвээ таныг хүсэлт гаргавал, тэр таны байцаалтууд болон нүүрэлдүүлэхэд оролцоно.

Энэ тохиолдолд, хүсэлтээ өмгөөлөгчид явуулсны дараа хоёр цагийн дотор эхний байцаалт зөвхөн таны биеийн байцаалтан дээр тулгуурлах ба түүнийг өмгөөлөгчгүйгээр эхлэх ёсгүй, эхний байцаалт таны биеийн байцаалтан дээр байна. Гэвч таны 1-р байцаалт мөрдөн байцаалтын шаардлагын дагуу Улсын прокурор (хяналтын прокурорын) зөвшөөрлөөр таны өмгөөлөгч байхгүй тохиолдолд ч нэн даруй эхэлж болно.

Таны байцаалт юмуу нүүрэлдүүлэх явцад таны өмгөөлөгч хүрэлцэн ирсэн тохиолдолд таны хүсэлтээр энэхүү үйл ажиллагааг өмгөөлөгчтэй ярилцах боломж олгож түр завсарлуулж болно.

Улсын прокурор (эсвэл хяналтын прокурор) ба Цагдан хорих болон суллах асуудлыг шийдвэрлэх эрх бүхий шүүгч нар хүндэтгэх шалтгаан болон онцгой тохиолдолд, байцаалтын үеийн таны өмгөөлөгчийн туслалцааг нэг удаа шинэчлэгдэх нөхцөлтэйгөөр 12 цагийн хугацаагаар хойшлуулах эрхтэй.

**Хэлмэрчийн туслалцаа**

Хэрэв та франц хэл ойлгодоггүй ба ярьдаггүй бол та байцаалтын үед өмгөөлөгчтэй ойлголцохын тулд үнэгүйгээр хэлмэрчийн туслалцаа авах эрхтэй.

**Цагдаад баривчлагдан хорих хугацааг дуусгавар болгохыг шаардах эрх**

Та Улсын прокуророос буюу Цагдан хорих болон суллах асуудлыг шийдвэрлэх эрх бүхий шүүгч ба хяналтын прокурораас цаашдын цагдаад хорих хугацааг сунгасан тохиолдолд уг арга хэмжээг авахгүй байхыг хүсэж болно.

**Таны хавтаст хэргийн зарим материалд хүрэх боломж**

Таны буюу таны өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу таны цагдаад хорих хугацааг сунгахын өмнө та доорхи зүйлсүүдтэй танилцаж болно:

- таныг цагдаад хорих болсон мэдэгдлийн протоколтой танилцах,
- танд үзлэг хийсэн эмчийн эмнэлгийн тодорхойлолтуудтай танилцах,
- танаас авсан байцаалтуудын протоколтой танилцах.